

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм, түүнд тавигдах шаардлага, гэрээний загвар”-ын 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

1/Гуравдугаар зүйл.Олон нийтийн цагдаад тавигдах шаардлага, түүнийг судлах, томилох, тоог тогтоох

“3.5.Энэ дүрмийн 3.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэнээс сургалтад хамруулахаар нэрсийн жагсаалтыг цагдаагийн байгууллагад ирүүлж болно.”.

2.Мөн дүрмийн 2.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/Хоёрдугаар зүйл.Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааны чиглэл

“2.3.Олон нийтийн цагдаагаар ажиллах иргэн цагдаагийн байгууллагын сургалтад хамрагдаж, чадамжийн гэрчилгээ олгогдсоны дараа Цагдаагийн албаны тухай хуулийн 63.8-д заасан таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, холбоо, нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгслийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь тавьж олгоно.”.

3.Мөн дүрмийн 3.1.3 дахь заалтын “энэ дүрмийн 2.3-д заасан сургалтад хамрагдаж, тэнцсэн байх;” гэснийг “энэ дүрмийн 2.3-д заасан сургалтад хамрагдаж, “Чадамжийн гэрчилгээ” авсан байх;” гэж, 4.3 дахь хэсгийн “Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг цагдаагийн төв байгууллагын Сургалт хариуцсан нэгж боловсруулж, цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэснийг “Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт батална.” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Дүрмийг алба хаагчдаар судлуулж, мөрдүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга /цагдаагийн хурандаа О.Ганбат/-д даалгасугай.

6.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА, ХОШУУЧ
ГЕНЕРАЛ

Ж.БОЛД